

Авлигатай тэмцэх газар

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийн маягт нөхөх заавар

Огноо: 2024

Улаанбаатар хот

Агуулга

ТАНИЛЦУУЛГА	3
НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ	4
1.1 ХАСУМ-ийн зорилго	4
1.2 Хэн гаргах вэ?	4
1.3 Хэзээ мэдүүлгээ гаргах вэ?	4
1.4 Хэрхэн мэдүүлэх вэ?	4
1.5 Хариуцлагын тухай	4
ХОЁР. МАЯГТЫН ХЭСЭГ	5
2.1 Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал	5
2.2 Мэдүүлэг гаргагч	5
2.3 Боловсролын талаарх мэдээлэл	7
2.4 Мэргэшлийн бэлтгэл	7
2.5 Төрийн албаны шалгалтын талаарх мэдээлэл	7
2.6 Ажил эрхлэлтийн байдал	8
2.7 Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал	8
3. Хувийн ашиг сонирхол	8
3.1 Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд	8
3.2 Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд	9
3.3 Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл	10
3.4 Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас	10

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү зааврыг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 1.6-д заасныг үндэслэн боловсруулсан болно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хүрээнд мэдүүлэг гаргах нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд нь хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэг хүлээдэг. Нэр дэвшигчээс уг үүргийнхээ хэрэгжилтийг хангахад нь дэмжлэг болох зорилгоор мэдүүлгийн маягтын талбар дахь анхаарах асуудал, нэр томъёоны тодорхойлолт, түгээмэл гардаг асуултад хариулсан байдлаар уг маягт нөхөх зааврыг боловсруулав.

Энэхүү мэдүүлгийг зөвхөн мэдүүлэг гаргадаг нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд гаргах бөгөөд сонгогддог албан тушаалтнуудад хамаарахгүй болно.

Санал, хүсэлт

Энэхүү маягт нөхөх зааврыг Авлигатай тэмцэх газраас тухай бүр боловсронгуй болгоход анхаарч ажиллаж байгаа бөгөөд заавартай холбоотой аливаа залруулга, санал, хүсэлтийг тус газрын contact@iaac.mn хаягаар ирүүлнэ үү.

Нэмэлт асуулт

Хэрэв Та мэдүүлгээ гаргах явцад энэхүү зааварт тодорхой тусгагдаагүй асуудалтай холбоотой нэмэлт асуулт гарвал өөрийн харьяа байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-д хандана уу.

НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ

1.1. ХАСУМ-ийн зорилго

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ) нь нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ашиг сонирхлын зөрчил үүсэх болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албанд шударга, ил тод байдлыг бэхжүүлэх, олон нийтийн хяналтыг бүрдүүлэхэд дэмжлэг болох зорилготой.

1.2. Хэн гаргах вэ?

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д заасан албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд ХАСУМ гаргана. Жагсаалтыг үзэх бол [Энд](#) дарна уу.

Харин сонгогддог албан тушаалтнууд ХАСУМ гаргахгүй.

1.3. Хэзээ мэдүүлгээ гаргах вэ?

“Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д заасан нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд нь уг албан тушаалд томилогдохын өмнө дээрх тогтоолоор баталсан “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 4.3.1-ийг үндэслэн дараах тохиолдолд ХАСУМ гаргана. Тухайлбал, шинээр, туршилтын хугацаанд, сэлгэн, шилжин, хавсран, хослон, түр орлон гүйцэтгэх гэм мэт.

Харин аж ахуйн нэгж, байгууллагын харьяалал, хуулийн этгээдийн хэлбэр, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн боловч эрхлэх асуудлын чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт ороогүй, Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажлын байрыг хэвээр хадгалж байсан, шүүхийн шийдвэрээр урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоосон бол дахин ХАСУМ гаргахгүй.

1.4. Хэрхэн мэдүүлэх вэ?

ХАСУМ-ийг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем (<https://meduuleg.iaac.mn/>)-д өөрийн эрхээр нэвтрэн орж, ЭБАТ-ны үүсгэсэн мэдүүлгийг үнэн зөв гаргаж, баталгааны маягтад гарын үсэг зурж томилогдохоор нэр дэвшсэн байгууллагын ЭБАТ-д хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

Мэдүүлэг гаргагч нь хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах, тайлбарлах үүрэгтэй.

Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас томилохын өмнө ХАСУМ-ийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт албан бичгийг “Ажлын байрны тодорхойлолт”-ын хамт хүргүүлнэ.

1.5. Хариуцлагын тухай

Мэдүүлэг гаргадаг албан тушаалд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5-д “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ” гэж заасны дагуу хянуулаагүй томилсон албан тушаалтанд уг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан хариуцлагыг хүлээлгэдэг.

ХОЁР. МАЯГТЫН ХЭСЭГ

2.1. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал

Энэ хэсэгт гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүн, гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа “хамтран амьдрагч”-ийг мэдүүлнэ. Өрх тусгаарлаагүй ч гадаад/дотоодод сурч байгаа буюу тусдаа амьдарч байгаа хүүхдийг мөн энэ хэсэгт мэдүүлнэ.

2.1.1 Мэдүүлэг гаргагч

Энэ хэсэгт мэдүүлэг гаргах үеийн байдлаар маягтын дагуу өөрийн мэдээллийг үнэн зөв мэдүүлнэ.

НЭГ. МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧ, ТҮҮНИЙ ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ:

1.1. Мэдүүлэг гаргагч		
Ургийн овог:	Эцэг/эхийн нэр:	Нэр:
Регистрийн дугаар: <input type="text"/>	Нэр дэвшсэн:	
Төрсөн газар:	- Байгууллагын нэр:	
Оршин суугаа газрын хаяг:	- Байгууллагын нэгж /газар, хэлтэс, тасаг, алба/-ийн нэр:	
Цахим шуудангийн хаяг:	- Албан тушаалын нэр:	
	- Албан тушаалын ангилал, зэрэглэл:	
	Гар утас:	Шаардлагатай үед холбоо барих утас:
Мэдүүлэг гаргах үндэслэл: /дэлгэрэнгүй бичих/		
1.1.1. Та болон таны хамаарал бүхий этгээд нь таны нэр дэвшсэн нийтийн алба (байгууллага), түүний салбар, нэгжийн үйл ажиллагаатай хамааралтай ашгийн төлөө үйл ажиллагааг сүүлийн 2 жилд эрхэлсэн эсэх (Аль тохирохыг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ.)		
<input type="checkbox"/> Тийм бол, тодорхой бичих. <input type="checkbox"/> Үгүй		
1.1.2. Та болон таны хамаарал бүхий этгээд оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хуулийн этгээд үүсгэн байгуулсан эсэх (Аль тохирохыг сонгон арын хүснэгтэд ✓ тэмдэглэгээ хийнэ.)		
<input type="checkbox"/> Тийм бол, тодорхой бичих. <input type="checkbox"/> Үгүй		

“Ургийн овог”, “Эцэг/эхийн нэр”, “Нэр”, “Регистрийн дугаар” гэдэгт мэдүүлэг гаргагч өөрийн мэдээллийг бичнэ. Гадаад улсын иргэн бол “регистрийн дугаар” хэсэгт гадаад паспортын дугаар, эсхүл Монгол Улсаас олгосон бүртгэлийн дугаарыг бичнэ.

“Төрсөн газар” гэдэгт мэдүүлэг гаргагчийн төрсний гэрчилгээнд бичигдсэн газрын нутаг дэвсгэрийн хаягийг одоогийн нэршлээр бичнэ.

“Оршин суугаа газрын хаяг” гэдэгт улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлсэн оршин суугаа газрын хаяг болон уг хаягаас өөр газарт амьдарч байгаа бол тухайн хаягийг мөн бичнэ.

“Нэр дэвшсэн” гэдэгт байгууллагын нэр, тухайн байгууллагын газар, хэлтэс, тасаг, албаны нэр, томилогдох албан тушаалын албан ёсны нэрийг бүтнээр, албан тушаалын ангилал, зэрэглэлийг тус тус бичнэ.

“Цахим шуудангийн хаяг” гэдэгт нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд өөрийн цахим шуудан /И-мэйл/-гийн хаягийг бичнэ.

“Гар утас”, “Шаардлагатай үед холбоо барих утас” гэдэгт мэдүүлэг гаргагчийн гар утас, ажлын утас болон шаардлагатай үед холбоо барих бусад хүний утасны дугаарыг бичнэ.

“Мэдүүлэг гаргах үндэслэл” гэдэгт Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшиж хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж байгаа тухайгаа дэлгэрэнгүй бичнэ. Тухайлбал:

- Мэдүүлэг гаргадаг нийтийн албан тушаалд шинээр томилогдохоор нэр дэвшсэн
- Мэдүүлэг гаргадаг нийтийн албан тушаалд туршилтын хугацаанд ажиллахаар нэр дэвшсэн,
- Мэдүүлэг гаргадаг нийтийн албан тушаалд сэлгэн ажиллахаар нэр дэвшсэн,
- Мэдүүлэг гаргадаг нийтийн албан тушаалд шилжин ажиллахаар нэр дэвшсэн,
- Мэдүүлэг гаргадаг нийтийн албан тушаалд хавсран ажиллахаар нэр дэвшсэн,
- Мэдүүлэг гаргадаг нийтийн албан тушаалд хослон ажиллахаар нэр дэвшсэн,
- Мэдүүлэг гаргадаг нийтийн албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллахаар нэр дэвшсэн г.м

“1.1.1. Та болон таны хамаарал бүхий этгээд нь таны нэр дэвшсэн нийтийн алба (байгууллага), түүний салбар, нэгжийн үйл ажиллагаатай хамааралтай ашгийн төлөө үйл ажиллагааг сүүлийн 2 жилд эрхэлсэн эсэх” асуултад нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хамаарал бүхий этгээд тухайн байгууллага, түүний салбар, нэгжийн үйл ажиллагаатай хамааралтай ашгийн төлөө үйл ажиллагааг сүүлийн 2 жилд эрхэлсэн буюу өөрөөр хэлбэл худалдах, худалдан авах гэрээ байгуулж хамтран ажилласан, тендер сонгон шалгаруулах үйл ажиллагаанд шалгарч байсан ажил гүйцэтгэж байсан эсэхийг “тийм”, “үгүй” гэсэн сонголтоос √ тэмдэглэгээ хийнэ. Хэрэв тийм бол хамаарал бүхий этгээд болон ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсан ААН-ийн нэр, ашгийн төлөө явуулсан үйл ажиллагааны талаар тодорхой бичнэ.

Энэ хэсэгт мэдүүлэг гаргагчийн хамаарал бүхий этгээд тухайн байгууллагатай хөдөлмөр эрхлэх зорилгоор байгуулсан гэрээний дагуу ажилласныг хамруулахгүй.

“1.1.2. Та болон таны хамаарал бүхий этгээд оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хуулийн этгээд үүсгэн байгуулсан эсэх” асуултад нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хамаарал бүхий этгээд оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хуулийн этгээд үүсгэн байгуулсан эсэхийг “тийм”, “үгүй” гэсэн сонголтоос √ тэмдэглэгээ хийнэ. Хэрэв тийм бол хамаарал бүхий этгээдийн нэр, данс нээсэн болон хөрөнгө байршуулсан банкны нэр, өмчилсөн хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл, үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн нэрийг тус тус тодорхой бичнэ.
(Оффшор бүсэд хамаардаг гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг дор оруулав)

Засгийн газрын 2017 оны 326 дугаар тогтоолын хавсралт “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт”

- | | |
|---------------------------|---------------------------------|
| 1. Ангиль, | 8. Бахрейны Хаант Улс, |
| 2. Андоррагийн Хант Улс, | 9. Белиз Улс, |
| 3. Антигуа Барбуда, | 10. Бермудын арал, |
| 4. Арабын Нэгдсэн Эмират, | 11. Ботсвана |
| 5. Аруба, | 12. Британийн Виржинийн арлууд, |
| 6. Барбадос Улс, | 13. Бруней, |
| 7. Бахамын арлууд, | 14. Бүгд Найрамдах Вануату Улс, |

15. Бүгд Найрамдах Кипр Улс,
16. Бүгд Найрамдах Коста-Рика Улс,
17. Бүгд Найрамдах Либери Улс,
18. Бүгд Найрамдах Ливан Улс,
19. Бүгд Найрамдах Мавритан Улс,
20. Бүгд Найрамдах Мальта Улс,
21. Бүгд Найрамдах Панам Улс,
22. Бүгд Найрамдах Уругвай Улс,
23. Гернси,
24. Гибралтар,
25. Гренад Улс,
26. Доминикийн Хамтын Нөхөрлөлийн
Улс,
27. Жерси,
28. Ирланд Улс,
29. Кайманы арлууд,
30. Куракао,
31. Куукийн арлууд,
32. Лихтенштейний Вант Улс,
33. Люксембург,
34. Макао,
35. Малайз,
36. Маршаллын арлууд,
37. Монако
38. Монтсеррат Улс,
39. Мэний арал,
40. Нидерландын Антилийн Арлууд,
41. Самоагийн Тусгаар улс,
42. Сейшелийн Арлын Бүгд Найрамдах
Улс,
43. Сент-Винсент-Гренадин Улс,
44. Сент-Китс-Невисийн Холбооны Улс,
45. Сент-Люси Улс,
46. Тёркс-кайкосын арлууд,
47. Хонконг

2.1.2 Боловсролын талаарх мэдээлэл

Энэ хэсэгт нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд өөрийн эзэмшсэн бүх боловсрол, мэргэжлийг жагсааж бичнэ.

1.1.3. Боловсролын талаарх мэдээлэл (Ерөнхий, тусгай дунд, дээд боловсролын, бакалаврын, дипломын, магистр, докторын зэргийг анх суралцсан дарааллаар бичнэ үү.)

№	Сургуулийн нэр	Элссэн он, сар	Төгссөн он, сар	Боловсролын түвшин	Эзэмшсэн мэргэжил	Гэрчилгээ, дипломын дугаар
1.						

2.1.3 Мэргэшлийн бэлтгэл

Энэ хэсэгт мэргэжлээрээ болон бусад чиглэлээр нарийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байдлыг жагсааж бичнэ.

1.1.4. Мэргэшлийн бэлтгэл (Мэргэжлээрээ болон бусад чиглэлээр нарийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байдлыг бичнэ үү.)

№	Хаана, ямар байгууллагад	Эхэлсэн/дууссан он, сар, өдөр	Хугацаа /хоноогоор/	Мэргэшлийн чиглэл
1.				

2.1.4 Төрийн албаны шалгалтын талаарх мэдээлэл

Энэ хэсэгт Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгч тэнцсэн огноо, албан тушаалын нэр, ангилал зэрэглэл мэдээллийг бичнэ. Мөн төрийн албаны нөөцөд байгаа эсэхийг “тийм”, “үгүй” гэсэн сонголтоос \surd тэмдэглэгээ хийнэ. Хэрэв “тийм” бол ерөнхий шалгалтад тэнцэж нөөцөд бүртгэгдснээс бусад тохиолдлын талаар мэдээллийг дэлгэрэнгүй бичнэ.

1.1.5. Төрийн албаны шалгалтын талаарх мэдээлэл

№	Мэдээллийн агуулга	Шалгалт өгч тэнцсэн огноо	Тусгай шалгалт өгсөн	
			Албан тушаалын нэр	Ангилал зэрэглэл
1.	Ерөнхий шалгалт			
2.	Тусгай шалгалт			
3.	Нөөцөд байгаа эсэх	<input type="checkbox"/> Тийм бол, тодорхой бичих <input type="checkbox"/> Үгүй		

2.1.5 Ажил эрхлэлтийн байдал

Энэ хэсэгт анх эрхэлсэн ажил, албан тушаалаас эхлэн одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал хүртэл нэг бүрчлэн жагсааж бичнэ.

1.1.6. Ажил эрхлэлтийн байдал (анх эрхэлсэн ажил, албан тушаалаас эхлэн бичнэ үү.)

№	Ажилласан байгууллагын нэр	Газар, хэлтэс, алба	Эрхэлсэн албан тушаал	Ажилд орсон он, сар	Ажлаас гарсан он, сар
1.					

2.1.6 Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

Энэ хэсэгт гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүн, гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа “хамтран амьдрагч”-ийг мэдүүлнэ. Мөн өрх тусгаарлаагүй гадаад/дотоодод сурч байгаа буюу тусдаа амьдарч байгаа хүүхдийг энэ хэсэгт мэдүүлнэ.

1.1.7. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

№	Таны юу болох	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар	Эрхэлж буй ажил, албан тушаалын нэр /сурч байгаа бол сургууль, цэцэрлэг г.м./	Оршин суугаа газрын хаяг
1.						

“Таны юу болох” гэдэгт хамтран амьдрагч болон гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүний аль нь болохыг бичнэ.

“Эцэг/эхийн нэр, нэр”, “Регистрийн дугаар”, “Төрсөн газар” гэдэгт гэр бүлийн гишүүний холбогдох мэдээллийг бичнэ.

“Эрхэлж буй ажил, албан тушаалын нэр /сурч байгаа бол сургууль, цэцэрлэг з.м./” гэдэгт хамтран амьдрагч болон гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд, төрөл, садангийн хүний эрхэлж буй ажил, албан тушаалын албан ёсны ёсны нэрийг, хэрэв ажил эрхэлдэггүй сурдаг бол сурч байгаа сургууль, цэцэрлэгийн нэрийг бичнэ.

“Оршин суугаа газрын хаяг” гэдэгт төрсөн газар гэдэгт хамтран амьдрагч болон гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд, төрөл, садангийн хүний оршин суугаа газрын хаягийг бичнэ.

3. ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ

3.1 Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд

Энэ хэсэгт мэдүүлэг гаргаж байгаа нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг мэдүүлнэ. “Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал”-д мэдүүлсэн гэр бүлийн гишүүдийг давхардуулан бичих шаардлагагүй. Энэ хэсэгт хуульд заасан бүх хамаарал бүхий этгээдийг мэдүүлнэ.

2.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд						
№	Таны юу болох	Хамаарал бүхий этгээдийн нэр	Төрсөн газар	Ажиллаж байгаа байгууллагын нэр /сурч байгаа бол сургууль/	Эрхэлж байгаа албан тушаалын нэр	Таны нэр дэвшсэн нийтийн алба, байгууллагад ажилладаг, түүний эрхлэх асуудал, харьяалах нутаг дэвсгэрт байгаа эсэх
1.						

“Таны юу болох” гэдэгт эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү болон эхнэр /нөхөр/, тэдний гэр бүл, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийн аль нь болохыг бичнэ.

“Хамаарал бүхий этгээдийн нэр” гэдэгт хамаарал бүхий этгээдийн эцэг /эх/-ийн болон өөрийнх нь нэрийг бичнэ.

“Төрсөн газар” гэдэгт хамаарал бүхий этгээдийн төрсөн газрын нэрийг бичнэ.

“Ажиллаж байгаа байгууллагын нэр /сурч байгаа бол сургууль/” гэдэгт хамаарал бүхий этгээдийн ажиллаж байгаа байгууллагын албан ёсны нэр, сурч байгаа бол сургуулийн нэрийг бичнэ.

“Эрхэлж байгаа албан тушаалын нэр” гэдэгт хамаарал бүхий этгээдийн эрхэлж байгаа албан тушаалын нэрийг бичнэ.

“Таны нэр дэвшсэн нийтийн алба, байгууллагад ажилладаг, түүний эрхлэх асуудал, харьяалах нутаг дэвсгэрт байгаа эсэх” гэдэгт тухайн хамаарал бүхий этгээд мэдүүлэг гаргагчийн нэр дэвшиж байгаа байгууллагад ажилладаг болон түүний эрхлэх асуудал, харьяалах нутаг дэвсгэрт нь байдаг эсэх мэдээллийг бичнэ.

3.2 Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд

Энэ хэсэгт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 3.1.7

дахь хэсэгт зааснаар тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаа буюу компани, нөхөрлөл, хувиараа аж ахуй эрхлэх зэрэг үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн /хуулийн этгээд/-ийг хамааруулж мэдүүлнэ. Мөн энэ хэсэгт мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч (ашиг хүртэгч), эсхүл хуулийн этгээдэд хөрөнгө оруулагч, хуулийн этгээдийн хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг эзэмшиж байгаа бол тухайн хуулийн этгээдийг энэ хэсэгт мэдүүлнэ.

Энэ хэсэгт дурдагдах хувь хүн хүн нь мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн гишүүн бөгөөд “Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал” хэсэгт мэдүүлсэн бол энд дахин мэдүүлэх шаардлагагүй.

2.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд				
№	Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Ямар харилцаатай болох /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/	Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл	Тайлбар
1.				

“Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нэр” гэдэгт нэгдмэл сонирхолтой этгээд нь хувь хүн бол эцэг /эх/-ийн болон өөрийнх нь нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэрийг бичнэ.

“Ямар харилцаатай болох” гэдэгт ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн болон ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой нөхөрлөл, компани болон тэдгээрийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, эцсийн өмчлөгч зэргийн аль нь болохыг бичнэ.

“Эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл” гэдэгт хуулийн этгээд бол үйл ажиллагааны чиглэлийг, хэрэв хувь хүн бол ашгийн төлөө хамтран ажиллаж байгаа үйл ажиллагааны чиглэлийг тус тус мэдүүлнэ.

“Тайлбар” гэдэгт хүснэгтийн холбогдох талбарт дурьдаагүй нэмэлт шаардлагатай мэдээлэл байгаа бол энэ хэсэгт дэлгэрэнгүй бичнэ

3.3 Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл

Энэ хэсэгт мэдүүлэг гаргагч нь нийгэмд үйлчилдэг болон гишүүддээ үйлчилдэг төрийн **бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага** зэрэг гишүүнчлэл бүхий ашгийн төлөө **бус байгууллагын** гишүүнчлэлийн талаар мэдүүлнэ.

2.3 Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл						
№	Төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага, төлөөлөн удирдах зөвлөл зэрэг гишүүнчлэл бүхий байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Үүсгэн байгуулагч, дарга, гүйцэтгэх захирал, гишүүний аль нь болох	Элссэн огноо	Тайлбар	
1.						

“Төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага зэрэг гишүүнчлэл бүхий ашгийн төлөө бус байгууллагын нэр” гэдэгт Төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллагын албан ёсны нэрийг бичнэ.

“Үйл ажиллагааны чиглэл” гэдэгт хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг бичнэ.

“Үүсгэн байгуулагч, дарга, гүйцэтгэх захирал, гишүүний аль нь болох” гэдэгт аль тохирох хэсгийг сонгож мэдүүлнэ.

“Элссэн огноо” гэдэгт төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага зэрэг гишүүнчлэл бүхий ашгийн төлөө бус байгууллагад хамгийн анх үүсгэн байгуулагч/ дарга/ гүйцэтгэх захирал/ гишүүн болсон огноог бичнэ.

“Тайлбар” гэдэгт хүснэгтийн холбогдох хэсэгт дурдаагүй нэмэлт шаардлагатай мэдээлэл байгаа бол энэ хэсэгт дэлгэрэнгүй бичих.

3.4 Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас

Энэ хэсэгт мэдүүлэг гаргагч өөрөө болон гэр бүлийн гишүүний Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд /ХК, ХХК, компанийн толгой, охин, хараат компани, компанийн нэгдэл, салбар, төлөөлөгчийн газар/, нөхөрлөл зэрэг ашгийн төлөө хуулийн этгээдэд эзэмшиж буй өмчлөлийн хувь, хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад нээлттэй, хаалттай үнэт цаасны талаар мэдүүлнэ. Тухайлбал, энэ хэсэгт компанийн хувьцаа (олон нийтэд нээлттэй арилжаалдаг болон арилжаалдаггүй), Засгийн газрын бонд, бусад бонд, вексель, хувьчлалын үнэт цаас/тасалбар, дериватив, опцион, фьючерс зэргийг мэдүүлнэ.

Мэдүүлгийн маягтын “Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд” хэсэгт мэдүүлсэн хуулийн этгээдэд хувь эзэмшдэг, эсхүл хөрөнгө оруулсан, эсхүл хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг эзэмшиж байгаа бол энэ хэсэгт хөрөнгийн хувь, хэмжээний талаар маягтын дагуу мэдүүлнэ.

3.12. Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас						
№	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувь нийлүүлсэн/оруулсан хөрөнгийн хэмжээ (төгрөг), хувь	Хөрөнгө оруулалтын төрөл, тоо	Нэгж хувьцааны анхны үнэ (төгрөг)	Тухайн жилд авсан ногдол ашиг (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.						
	Нийт дүн					

“Хуулийн этгээдийн нэр, хэлбэр” гэдэгт Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн албан ёсны нэр, хэлбэр /Хязгаарлагдмал хариуцлагатай компани ХХК, хувьцаат компани ХК, нөхөрлөл/-ийг бичнэ.

“Хувь нийлүүлсэн/оруулсан хөрөнгийн хэмжээ, хувь /төгрөг/” гэдэгт мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн Монгол Улсын болон гадаад улсын ашгийн төлөө хуулийн этгээдэд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг мэдүүлнэ.

“Хөрөнгө оруулалтын төрөл, тоо” гэдэгт мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо ширхэг, төрөл /энгийн, давуу эрхийн/-ийг бичнэ.

“Тухайн жилд авсан ногдол ашиг/төгрөг” гэдэгт тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон компанийн Хувь нийлүүлэгч/хөрөнгө оруулагчид хуваарилсан ногдол ашгийг бичнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” гэдэгт мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний худалдан авсан хувьцаа/үнэт цаасны тоо ширхгийг, худалдан авсан үнийг төгрөгөөр илэрхийлж, ийнхүү худалдан авсан эх үүсвэрийг тодорхой бичнэ.

---oOo---

Авлигатай тэмцэх газар

**Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон
хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийн маягт нөхөх заавар**

Огноо: 2024/.../...

Улаанбаатар хот

Агуулга

ТАНИЛЦУУЛГА.....	3
НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ	4
1.1. ХАСХОМ-ийн зорилго	4
1.2. Хэн гаргах вэ?	4
1.3. Хэзээ мэдүүлгээ гаргах вэ?	4
1.4. Хэрхэн мэдүүлэх вэ?	4
1.5. Хариуцлагын тухай	4
ХОЁР. МАЯГТЫН ХЭСЭГ	4
2.1. Мэдүүлгийн хамрах хугацаа.....	5
2.2. Үнийн дүнг төгрөгөөр илэрхийлэх нь	16
2.3. Мэдүүлэгт тусгах болон тусгахгүй хөрөнгийн доод хэмжээ	16
2.4. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал	5
2.4.1. Мэдүүлэг гаргагч	17
2.4.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал.....	17
2.5. Хувийн ашиг сонирхол.....	34
2.5.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд	35
2.5.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд	19
2.5.3. Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл.....	19
2.5.4. Төрийн байгууллагатай байгуулсан гэрээ	20
2.5.5. Давхар ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл	20
2.5.6. Бэлэг, хандив, өв залгамжлал	20
2.6. ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЗЭЭЛ	22
2.6.1. Орлого	22
2.6.2. Орон сууц, барилга, байгууламж.....	23
2.6.3. Тээврийн хэрэгсэл.....	24
2.6.4. Тоног төхөөрөмж	24
2.6.5. Мал, амьтан.....	25
2.6.6. Газар	25
2.6.7. Үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйл.....	26
2.6.8. Бэлэн мөнгө, харилцах, хадгаламж, картын дансны үлдэгдэл	26
2.6.9. Виртуал хөрөнгө	27
2.6.10. Авлага	27
2.6.11. Зээл.....	27
2.6.12. Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас	11
2.6.13. Эрх, патент	29

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү зааврыг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтын дагуу хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар зааварчилгаа гаргах Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг болон УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 1.6-д заасныг үндэслэн боловсруулсан болно.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хүрээнд мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтан нь хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх, хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэг хүлээдэг. Албан тушаалтнаас уг үүргийнхээ хэрэгжилтийг хангахад нь дэмжлэг болох зорилгоор мэдүүлгийн маягтын талбар дахь анхаарах асуудал, нэр томъёоны тодорхойлолт, түгээмэл гардаг асуултад хариулсан байдлаар уг маягт нөхөх зааврыг боловсруулав.

Санал, хүсэлт

Энэхүү маягт нөхөх зааврыг Авлигатай тэмцэх газраас тухай бүр боловсронгуй болгоход анхаарч ажиллаж байгаа бөгөөд заавартай холбоотой аливаа залруулга, санал, хүсэлтийг тус газрын contact@iaac.mn хаягаар ирүүлнэ үү.

Нэмэлт асуулт

Хэрэв Та мэдүүлгээ гаргах явцад энэхүү зааварт тодорхой тусгагдаагүй асуудалтай холбоотой нэмэлт асуулт гарвал өөрийн харьяа байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах Эрх Бүхий Албан Тушаалтан (ЭБАТ)-д хандана уу.

НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ

1.6. ХАСХОМ-ийн зорилго

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ) нь албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчил үүсэх болон үндэслэлгүйгээр хөрөнгөжихөөс урьдчилан сэргийлэх, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, нийтийн албанд шударга, ил тод байдлыг бэхжүүлэх, олон нийтийн хяналтыг бүрдүүлэхэд дэмжлэг болох зорилготой.

1.7. Хэн гаргах вэ?

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д заасан албан тушаалтан ХАСХОМ гаргана. Жагсаалтыг үзэх бол [ЭНД](#) дарна уу.

1.8. Хэзээ мэдүүлгээ гаргах вэ?

“Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-д заасан албан тушаалтан нь дараахь тохиолдолд ХАСХОМ гаргана. Үүнд:

- тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор шинээр,
- цаашид албан тушаалыг эрхэлж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн,
- хөрөнгө, орлого нь 1 (нэг) сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь (250) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол энэ тухай ийнхүү өөрчлөлт орсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор тус тус мэдүүлгээ гаргана.

Харин тухайн жилийн мэдүүлгээ шинэчлэн гаргасан албан тушаалтан мэдүүлгээ гаргасан байгууллагын бүтцийн нэгж дотор дахин албан тушаалд томилогдсон бол ХАСХОМ-ийг 30 хоногийн дотор дахин гаргахгүй байж болно.

1.9. Хэрхэн мэдүүлэх вэ?

ХАСХОМ-ийг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем (<https://meduuleg.iaac.mn/>)-д өөрийн эрхээр нэвтрэн орж, ЭБАТ-ны үүсгэсэн мэдүүлгийг үнэн зөв гаргаж, баталгааны маягтад гарын үсэг зурж өөрийн харьяа байгууллагын ЭБАТ-д хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

Мэдүүлэг гаргагч нь хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх, хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй.

Хөрөнгө, орлого нь 1 (нэг) сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь (250) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн үндэслэлээр мэдүүлгээ гаргаж байгаа бол зөвхөн өөрчлөлт орсон хэсгийн мэдээллийг шинэчлэн мэдүүлнэ.

1.10. Хариуцлагын тухай

Мэдүүлэг гаргагч албан тушаалтан нь ХАСХОМ-ээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8, 33 дугаар зүйлийн 33.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь хэсэгт заасан хариуцлагыг хүлээлгэдэг. Мөн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлийн 22.10-т заасан хариуцлагыг тус тус хүлээлгэдэг.

ХОЁР. МАЯГТЫН ХЭСЭГ

2.1. Мэдүүлгийн хамрах хугацаа

Мэдүүлэг гаргагч тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор шинээр (Шинээр томилогдсон /сонгогдсон), цаашид албан тушаалыг эрхэлж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн (2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн), хөрөнгө, орлого нь 1 (нэг) сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь (250) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол энэ тухай ийнхүү өөрчлөлт орсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор (Хөрөнгө, орлогод орсон өөрчлөлт) тус тус мэдүүлгээ гаргана. Мэдүүлэг гаргахдаа дараахь хамрах хугацаа баримтална.

Мэдүүлгийн хамрах хугацаа

Маягтын хэсэг	ХАСХОМ-ийг мэдүүлэхэд хамрах хугацаа		
	Шинээр томилогдсон/ сонгогдсон	2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн	Хөрөнгө, орлогод орсон өөрчлөлт
Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал	Томилогдох, сонгогдох үеийн байдлаар	Өмнөх оны 12 сарын 31-ний байдлаар	Мэдүүлэхгүй
Хоёр. Хувийн ашиг сонирхол			
Үүнээс: - Давхар ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл - Бэлэг, хандив, өв залгамжлал	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	
Гурав. Хөрөнгө, орлого, зээл			
- Орлого	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	Өөрчлөлт орсон үеийн байдлаар, өөрчлөлт орсон хэсгийг шинэчлэн мэдүүлнэ
- Хөрөнгө (орон сууц, барилга, байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, мал, амьтан, газар, үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйл, бэлэн мөнгө, харилцах, хадгаламж, картын дансны үлдэгдэл, виртуал хөрөнгө, авлага, хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас, эрх, патент)	Өмнөх оны 12 сарын 31-ний байдлаар	Өмнөх оны 12 сарын 31-ний байдлаар	
- Зээл	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	Өмнөх хуанлийн жилийн байдлаар	

2.2. Үнийн дүнг төгрөгөөр илэрхийлэх нь

Мэдүүлгийн маягт дахь мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх талбаруудыг төгрөгөөр илэрхийлж (мянга, сая гэх мэт оронд шилжүүлэхгүй) бичнэ. Хэрэв тухайн мөнгөн дүн нь гадаад валютаар илэрхийлэгдэх бол орлогыг тухайн орлого олох үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны валютын ханшаар, харин хөрөнгө, зээлийг тухайн мэдүүлэг гаргах оны урьд оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанкнаас зарласан албан ёсны валютын ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцож мэдүүлнэ.

2.3. Мэдүүлэгт тусгах болон тусгахгүй хөрөнгийн үнийн доод хэмжээ

Маягтын хөрөнгө, орлого, зээл хэсгийн “Тоног төхөөрөмж”, “Үнэт эдлэл, урлаг түүх, соёлын үнэт зүйлс” хэсэгт мэдүүлэх хөрөнгийн зах зээлийн үнийн дүнгийн хэмжээ, эсхүл энэ төрлийн хөрөнгийн зах зээлийн үнийн дүнгийн нийлбэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг **20** ба түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй бол мэдүүлнэ. Дээр дурдсанаас бусад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, орлого, бэлэн мөнгө, харилцах, хадгаламж, картын данс, виртуал хөрөнгө, зээл, авлага, хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаасны хувьд ямар нэгэн үнийн дүнгийн доод хэмжээ харгалзахгүйгээр мэдүүлэгт тусгана.

2.4. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал

2.4.1. Мэдүүлэг гаргагч

“Мэдүүлэг гаргагч” хэсэгт мэдүүлэг гаргагч нь маягтын дагуу өөрийн мэдээллийг үнэн зөв мэдүүлэх бөгөөд мэдүүлэг гаргаж буй үндэслэлийг сонгосон байна.

1.1. Мэдүүлэг гаргагч		
Ургийн овог:	Эцэг/эхийн нэр:	Нэр:
Регистрийн дугаар: <input type="text"/>	Байгууллагын нэр:	
Иргэншил:	Нэгж /газар, хэлтэс, тасаг, алба/-ийн нэр:	
Төрсөн газар:	Албан тушаалын нэр:	
Оршин суугаа газрын хаяг болон бусад хаяг:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:	
Боловсрол, мэргэжил:	Цахим шуудангийн хаяг:	
Гар утас:	Шаардлагатай үед холбоо барих утас:	Тухайн албан тушаалд томилогдсон/сонгогдсон огноо:
Ажлын утас:	... он ... сар ... өдөр	
Та мэдүүлэг гаргах үндэслэлээс аль тохирохыг сонгон ✓ гэж тэмдэглэнэ үү. <input type="checkbox"/> Тухайн албан тушаалд томилогдсон/сонгогдсон/ өдрөөс хойш 30 хоногийн дотор <input type="checkbox"/> Тухайн алба хааж байх хугацаандаа шинэчлэн гаргасан (жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор) <input type="checkbox"/> Хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол (тухай бүр 30 хоногийн дотор)		

“Ургийн овог”, “Эцэг/эхийн нэр”, “Нэр”, “Регистрийн дугаар” хэсэгт мэдүүлэг гаргагч өөрийн мэдээллийг бичнэ. Гадаад улсын иргэн бол “регистрийн дугаар” хэсэгт гадаад паспортын дугаар, эсхүл Монгол Улсаас олгосон бүртгэлийн дугаарыг бичнэ.

“Иргэншил” хэсэгт аль улсын иргэн болохоо бичнэ.

“Төрсөн газар” хэсэгт мэдүүлэг гаргагчийн төрсний гэрчилгээнд бичигдсэн газрын нутаг дэвсгэрийн хаягийг одоогийн нэршлээр бичнэ.

“Оршин суугаа газрын хаяг болон бусад хаяг” хэсэгт улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн санд бүртгүүлсэн хаяг болон оршин суугаа газрын хаягийг бичнэ.

“Боловсрол, мэргэжил” хэсэгт мэдүүлэг гаргагчийн эзэмшсэн бүх боловсрол, мэргэжлийг жагсааж бичнэ.

“Гар утас”, “Ажлын утас”, “Шаардлагатай үед холбоо барих утас” хэсэгт мэдүүлэг гаргагчийн гар утас, ажлын утас болон шаардлагатай үед холбоо барих утасны дугаарыг бичнэ.

“Байгууллагын нэр”, “Нэгж /газар, хэлтэс, тасаг, алба/-ийн нэр” хэсэгт мэдүүлэг гаргагчийн ажиллаж байгаа байгууллагын албан ёсны нэрийг, мөн мэдүүлэг гаргагчийн ажиллаж байгаа нэгж /газар, хэлтэс, тасаг, алба/-ийн нэрийг тухайн байгууллагын шийдвэрээр баталгаажсанаар товчлохгүй бичнэ.

“Албан тушаалын нэр” хэсэгт мэдүүлэг гаргагчийн эрхэлж байгаа албан тушаалын нэрийг тухайн байгууллагын шийдвэрээр баталгаажсанаар бичнэ.

“Албан тушаалын ангилал, зэрэглэл” хэсэгт Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад салбарын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосноор мэдүүлэг гаргах үед эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэлийг;

“Цахим шуудангийн хаяг” хэсэгт мэдүүлэг гаргагчийн цахим шуудан /И-мэйл хаяг/-гийн хаягийг бичнэ.

“Тухайн албан тушаалд томилогдсон/сонгогдсон огноо” хэсэгт мэдүүлэг гаргах үед эрхэлж байгаа албан тушаалд томилогдсон/сонгогдсон он, сар, өдрийг бичнэ.

“Мэдүүлэг гаргах үндэслэл” хэсэгт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан аль үндэслэлийн дагуу мэдүүлэг гаргаж байгаагаа сонгоно. Зарим тохиолдолд 1-ээс дээш үндэслэлээр мэдүүлэг гаргахаар бол холбогдох үндэслэл бүрийг сонгоно.

2.4.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

Энэ хэсэгт гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон **төрөл, садангийн хүн**, гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа “хамтран амьдрагч”-ийг мэдүүлнэ.

1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал						
№	Таны юу болох	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар	Эрхэлж буй ажил, албан тушаалын нэр /сурч байгаа бол сургууль, цэцэрлэг г.м./	Оршин суугаа газрын хаяг
1.						

“Таны юу болох” гэдэгт хамтран амьдрагч болон гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүний аль нь болохыг бичнэ.

“Эцэг/эхийн нэр, нэр”, “Регистрийн дугаар”, “Төрсөн газар” хэсэгт гэр бүлийн гишүүний холбогдох мэдээллийг бичнэ.

“Эрхэлж буй ажил, албан тушаалын нэр /сурч байгаа бол сургууль, цэцэрлэг г.м./” гэдэгт хамтран амьдрагч болон гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд, төрөл, садангийн хүний эрхэлж буй ажил, албан тушаалын албан ёсны нэрийг, хэрэв ажил эрхэлдэггүй сурдаг бол сурч байгаа сургууль, цэцэрлэгийн нэрийг бичнэ.

“Оршин суугаа газрын хаяг” гэдэгт төрсөн газар гэдэгт хамтран амьдрагч болон гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд, төрөл, садангийн хүний оршин суугаа газрын хаягийг бичнэ.

2.5. Хувийн ашиг сонирхол

Мэдүүлэг гаргагч нь шинээр сонгогдсон/томилогдсон бол томилогдсон/сонгогдсон үеийн байдлаар, шинэчлэн гаргаж байгаа бол урьд оны 12 сарын 31-ний байдлаар тус тус хувийн ашиг сонирхлоо маягтын дагуу мэдүүлнэ.

2.5.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь хэсэгт зааснаар мэдүүлэг гаргаж байгаа нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг талаар энэ хэсэгт мэдүүлнэ.

Энэ хэсэгт мэдүүлгийн “Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал”-д мэдүүлсэн гэр бүлийн гишүүдийг давхардуулан бичих шаардлагагүй, харин өрх тусгаарласан хүүхдийг мэдүүлнэ.

2.1 Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд					
№	Таны юу болох	Хамаарал бүхий этгээдийн нэр	Төрсөн газар	Ажиллаж байгаа байгууллагын нэр /сурч байгаа бол сургууль/	Эрхэлж байгаа албан тушаалын нэр
1.					

“Таны юу болох” хэсэгт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т зааснаар мэдүүлэг гаргаж байгаа нийтийн албан тушаалтны эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү болон эхнэр /нөхөр/, тэдний гэр бүл, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийн аль нь болохыг бичнэ. Энэ хэсэгт хуульд заасан бүх хамаарал бүхий этгээдийг мэдүүлнэ.

“Хамаарал бүхий этгээдийн нэр” хэсэгт хамаарал бүхий этгээдийн эцэг /эх/-ийн болон өөрийнх нь нэрийг тус тус бичнэ.

“Төрсөн газар” хэсэгт хамаарал бүхий этгээдийн төрсөн газрын нэрийг бичнэ.

“Ажиллаж байгаа байгууллагын нэр /сурч байгаа бол сургууль/” гэдэгт хамаарал бүхий этгээдийн ажиллаж байгаа байгууллагын албан ёсны нэр, сурч байгаа бол сургуулийн нэрийг бичнэ.

“Эрхэлж байгаа албан тушаалын нэр” хэсэгт хамаарал бүхий этгээдийн эрхэлж байгаа албан тушаалын нэрийг бичнэ.

2.5.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 3.1.7 дахь хэсэгт зааснаар тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаа буюу компани, нөхөрлөл, хувиараа аж ахуй эрхлэх зэрэг үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн /хуулийн этгээд/-ийг хамааруулж мэдүүлнэ. Мөн энэ хэсэгт мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч (ашиг хүртэгч), эсхүл хуулийн этгээдэд хөрөнгө оруулагч, хуулийн этгээдийн хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг эзэмшиж байгаа бол тухайн хуулийн этгээдийг энэ хэсэгт мэдүүлнэ. Харин эдгээр хуулийн этгээдэд эзэмшиж буй хөрөнгийн талаар дэлгэрэнгүй байдлаар маягтын хөрөнгө, орлого, зээл талбарын “Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд” хэсэгт мэдүүлнэ.

Энэ хэсэгт дурдагдах хувь хүн нь мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн гишүүн бөгөөд “Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал” хэсэгт мэдүүлсэн бол дахин мэдүүлэх шаардлагагүй.

2.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд				
№	Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Ямар харилцаатай болох /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/	Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл	Тайлбар
1.				

“Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нэр” хэсэгт нэгдмэл сонирхолтой этгээд нь хувь хүн бол эцэг /эх/-ийн болон өөрийнх нь нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэрийг товчлохгүйгээр тус тус бичнэ.

“Ямар харилцаатай болох” гэдэгт ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн болон ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой нөхөрлөл, компани болон тэдгээрийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, эцсийн өмчлөгч зэргийн аль нь болохыг бичнэ.

“Эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл” гэдэгт хуулийн этгээд бол үйл ажиллагааны чиглэлийг, хэрэв хувь хүн бол ашгийн төлөө хамтран ажиллаж байгаа үйл ажиллагааны чиглэлийг тус тус мэдүүлнэ. **“Тайлбар”** гэдэгт энэ хэсэгт дурдаагүй нэмэлт шаардлагатай мэдээллийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

2.5.3. Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл

Мэдүүлэг гаргагч нь нийгэмд үйлчилдэг болон гишүүддээ үйлчилдэг төрийн **бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага** зэрэг гишүүнчлэл **бүхий ашгийн төлөө бус байгууллагын** гишүүнчлэлийн талаар мэдүүлнэ.

2.3 Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл					
№	Төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага, төлөөлөн удирдах зөвлөл зэрэг гишүүнчлэл бүхий байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Үүсгэн байгуулагч, дарга, гүйцэтгэх захирал, гишүүний аль нь болох	Элссэн огноо	Тайлбар
1.					

“Төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага зэрэг гишүүнчлэл бүхий ашгийн төлөө бус байгууллагын нэр” гэдэгт Төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллагын албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичнэ.

“Үйл ажиллагааны чиглэл” гэдэгт хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг бичнэ.

“Үүсгэн байгуулагч, дарга, гүйцэтгэх захирал, гишүүний аль нь болох” гэдэгт аль тохирох хэсгийг сонгож мэдүүлнэ.

“Элссэн огноо” гэдэгт төрийн бус байгууллага, холбоо, сан, хоршоо, улс төрийн нам, олон нийтийн байгууллага зэрэг гишүүнчлэл бүхий ашгийн төлөө бус байгууллагад хамгийн анх үүсгэн байгуулагч/ дарга/ гүйцэтгэх захирал/ гишүүн болсон огноог бичнэ.

“Тайлбар” гэдэгт энэ хэсэгт дурдаагүй нэмэлт шаардлагатай мэдээллийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

2.5.4. Өөрийн болон хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхол

Мэдүүлэг гаргагч болон гэр бүлийн гишүүн, эсхүл түүний хамаарал бүхий этгээд, эцсийн өмчлөгч нь болдог хуулийн этгээд тухайн мэдүүлэг гаргагчийн ажиллаж байгаа байгууллага /түүний салбар, нэгж/-тай мэдүүлэг гаргасан хугацаанаас өмнөх 2 жилийн хугацаанд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд шалгарах, тусгай зөвшөөрөл авах, гэрээ, контракт байгуулах, хяналт шалгалт явуулах, хариуцлага хүлээлгэх зэрэг аливаа хэлбэрийн үйл ажиллагаанд оролцсон бол энэ хэсгийг “тийм” гэж тэмдэглэн, хэзээ, хаана, ямар үйл ажиллагаанд оролцсон, гэрээ байгуулсан бол ямар гэрээг байгуулсан талаар тодорхой дурдаж бичнэ. Энэ хэсэгт мэдүүлэг гаргагчийн зүгээс тухайн байгууллагатай хөдөлмөр эрхлэх зорилгоор байгуулсан гэрээг хамруулахгүй.

<p>2.4. Та болон таны хамаарал бүхий этгээд нь таны ажиллаж байгаа байгууллага /түүний салбар, нэгж/-д сүүлийн 2 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд шалгарах, тусгай зөвшөөрөл авах, гэрээ, контракт байгуулах, хяналт шалгалт явуулах, хариуцлага хүлээлгэх зэрэг үйл ажиллагаанд оролцсон эсэх (аль тохирохыг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ).</p>	
<input type="checkbox"/> Тийм бол, тодорхой бичих.	<input type="checkbox"/> Үгүй

2.5.5. Давхар ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

Мэдүүлэг гаргагч нь мэдүүлэг гаргахын өмнөх хуанлийн жилийн хугацаанд албан тушаал эрхэлж байх хугацаандаа тухайн байгууллагаас бусад байгууллага, хуулийн этгээдэд давхар эрхэлсэн ажлын талаар мэдүүлнэ. Тухайлбал, бусад аж ахуйн нэгж, байгууллагад эрхэлсэн, эсхүл гэрээний үндсэн дээр цалин, хөлс авч гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, бүтээлч ажил болон Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар бусад байгууллагад өөр ажил хослон, хавсран гүйцэтгэсэн бол давхар ажил эрхэлсэн гэж үзэж энэ хэсэгт мэдүүлнэ. Мөн Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар /аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар/-т төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнээр байсан эсхүл байгаа бол энэ тухай бичнэ. Давхар ажил эрхэлж орлого олсон бол маягтын орлого хэсэгт мөн мэдүүлэхийг анхаарна уу.

Энэ хэсэгт дээр дурдсанаас бусад хууль болон олон улсын гэрээгээр тусгайлан зөвшөөрсөн ажил, эсхүл багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил, эсхүл татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагааны талаар мэдүүлэх шаардлагагүй.

2.5. Давхар ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл				
№	Байгууллагын нэр	Албан тушаалын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тайлбар
1.				

“**Байгууллагын нэр**” хэсэгт Мэдүүлэг гаргагч нь давхар ажил эрхэлсэн байгууллага, хуулийн этгээдийн нэрийн бичнэ.

“**Албан тушаалын нэр**” хэсэгт ямар ажил, албан тушаалтыг давхар эрхэлсэн талаар мэдүүлнэ.

“**Үйл ажиллагааны чиглэл**” хэсэгт дээрх байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг бичнэ.

“**Тайлбар**” хэсэгт хэдий хугацаанд ямар чиг үүргийн ажлыг гүйцэтгэсэн талаар, мөн энэ хугацаанд цалин, урамшуулал авсан эсэх талаар энэ хэсэгт мэдүүлнэ.

2.5.6. Бэлэг, хандив, өв залгамжлал

Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүн нь бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн бэлэг, хандив, мөн хууль ёсоор өвлүүлэгчээс өвлөгдсөн эд хөрөнгө зэргийг мэдүүлнэ.

2.6. Бэлэг, хандив, өв залгамжлал								
№	Эх сурвалжийн нэр (бэлэг, өв залгамжлал, хандив өгсөн хувь хүн, хуулийн этгээд)	Ямар хамааралтай болох	Огноо	Бэлэг, хандив, өв залгамжлалын аль нь болох	Хүлээн авсан эд хөрөнгө /эрх/-ийн нэр	Зориулалт	Үнэлгээ (төгрөгөөр)	Тайлбар
1.								
Нийт дүн								

“Эх сурвалжийн нэр” хэсэгт мэдүүлэг гаргагчид бэлэг, өв залгамжлал, хандив өгсөн этгээдийн нэрийг тодорхой /товчлохгүй/ бичнэ.

“Ямар хамааралтай болох” бэлэг, өв залгамжлал, хандив өгсөн этгээдтэй мэдүүлэг гаргагч нь ямар хамааралтай болохоо бичнэ.

“Огноо” бэлэг, өв залгамжлал, хандивыг хүлээн авсан огноог бичнэ.

“Бэлэг, хандив, өв залгамжлалын аль нь болох” хэсэгт бэлэг, хандив, өв залгамжлалын аль нь болохыг бичих бөгөөд тэдгээрийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

“Бэлэг” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан /3 дугаар зүйлийн 3.1.9/-аар нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг ойлгоно.

“Хандив” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан /3 дугаар зүйлийн 3.1.8/-аар нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг ойлгоно.

“Өв залгамжлал” гэдгийг Иргэний хууль /53 дугаар бүлэг/-д зааснаар ойлгоно.

“Хүлээн авсан эд хөрөнгө /эрх-ийн нэр” бэлэг, өв залгамжлал, хандивын хүрээнд хүлээн авсан хөрөнгийн нэрийг бичнэ.

“Зориулалт” гэдэгт авсан тухайн бэлэг, хандивыг ямар арга хэмжээ, үйл явдал, юунд зориулан/тохиолдуулан өсгөн талаар тодорхой бичнэ.

“Үнэлгээ” гэдэгт бэлэг, хандивын үнэ/дүн/-ийг тухайн жилийн эцсийн зах зээлийн үнэлгээг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

“Тайлбар” хүснэгтийн холбогдох хэсэгт дурдаагүй нэмэлт шаардлагатай мэдээлэл байгаа бол энэ хэсэгт дэлгэрэнгүй бичих.

2.6. ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЗЭЭЛ

Маягтын энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлгийн хамрах хугацаанд зааснаар үнэн, зөв мэдүүлнэ. Үүнд:

2.6.1. Орлого

Энэ дэд хэсэгт урьд оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-нийг дуустал жилийн хугацаанд олсон орлогыг төрөл тус бүрээр (татвар, шимтгэл төлсний дараах) нийт дүнгээр эх үүсвэрийн хамт мэдүүлнэ.

3.1. Орлого				
№	Орлогын төрөл	Орлогын нийт дүн (төгрөгөөр)		Орлогын эх үүсвэр
		Өөрийн	Гэр бүлийн гишүүний	
1.	Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого			
2.	Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого (албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал)			
3.	Үйл ажиллагааны орлого (үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого, цахим болон интернэт сүлжээний борлуулалтын орлого)			
4.	Хөрөнгийн орлого (түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусад ашиглуулсны орлого)			
5.	Хөрөнгө борлуулсны орлого (хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны, шилжүүлсний орлого)			
6.	Хандивын орлого (бусдаас авсан мөнгөн хандив, тусламж)			
7.	Бусад орлого (шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого гэх мэт)			
Нийт дүн				

“Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого” гэдэгт-Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /7 дугаар зүйл/-д зааснаар ойлгох ба албан тушаалтан өөрийн болон гэр бүлийн гишүүдийн тухайн календарийн жилд гарт олгосон цалин хөлс буюу ажил олгогчийн албан ёсны баримтыг үндэслэн татвар, шимтгэл хасагдсаны дараах цэвэр дүнг мэдүүлнэ.

“Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”-д дараах орлогыг хамааруулна. Үүнд:

- ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд зааснаар болон эрх бүхий байгууллагаас тогтоосноор эсхүл сүлжээ, тарифын дагуу олгож байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;

- ажил олгогчоос ажилтан, албан хаагч түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого;

- ажил олгогчоос ажилтан, албан хаагч түүний гэр бүлийн гишүүнд өгсөн бэлэг;

- төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

- гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого;

- үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; Энэхүү орлогод мэдүүлгийн 2.6 дахь хэсэгт заасан “Давхар ажил эрхлэлт”-ийн орлого хамаарна.

- хоол, унааны мөнгө

“Үйл ажиллагааны орлого” гэдэгт үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого буюу Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /8 дугаар зүйл/-д зааснаар хуулийн этгээд байгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж олсон орлогыг болон тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна. Үүнд:

- бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого;

- хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;

- шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого;
- эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор үнэ төлбөргүй бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээ.
- цахим болон интернэт сүлжээг ашигласнаас олсон орлого.

“Хөрөнгийн орлого” гэдэгт Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /9 дүгээр зүйл/-д хөрөнгө ашиглуулсан болон түрээслүүлсний орлого, эрхийн шимтгэлийн орлого, ногдол ашгийн орлого, хүүгийн орлого, гадаад, дотоодын хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасны орлого, бусдаас авсан авлагын орлого хамаарна.

“Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого” гэдэгт Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /10 дугаар зүйл/-д үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого, газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, /эрх/ шилжүүлсний орлого, хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого, хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого, мөн биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар төлөгч өөрийн эдийн бус хөрөнгө өмчлөх эрхийг хуульд заасны дагуу бусдад шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна.

“Хандивын орлого” гэдэгт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д зааснаар нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар олгож байгаа, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр олгосон санхүүгийн эх үүсвэр, шилжүүлсэн эд хөрөнгө, үзүүлсэн үйлчилгээний үнийг хамааруулна. Хандиваар буюу энэ мэдүүлгийн 2.5 дахь хэсэгт зааснаар хүлээн авсан санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгийн орлого энэ хэсэгт хамаарна.

“Бусад орлого” гэдэгт дээр зааснаас бусад орлого, нөхөн төлбөр, санхүүгийн дэмжлэг, тэтгэмж, тусламж, буцаан олголт зэрэг орлогыг хамааруулна.

2.6.2. Орон сууц, барилга, байгууламж

Мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөлийн эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэлтэй эсхүл бүртгэлгүй /баригдаж дуусаагүй, баригдсан боловч албан ёсоор гэрчилгээ аваагүй г.м/ дуусаагүй барилгыг Орон сууцны тухай хууль /3 дугаар зүйл/-д зааснаар хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэр, мөн газраас салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмсад хамаарах үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, хашаа байшин, зуслангийн байр, хүлэмж, өвөлжөө, хаваржаа, намаржаа зэрэг үл хөдлөх хөрөнгийг мэдүүлнэ. Энэ хэсэгт гадаад улс, оффшор болон чөлөөт бүсэд өмчлөлд байгаа орон сууц, барилга, байгууламжийг урьд оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх хөрөнгийг эх үүсвэрийн хамт тодорхой мэдүүлнэ.

3.2. Орон сууц, барилга, байгууламж								
№	Орон сууц, барилга, байгууламжийн төрөл	Улсын бүртгэлийн дугаар	Байршил /хаяг/	Хийц, талбайн хэмжээ, өрөөний тоо	Өмчлөгчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Анхны үнэ (төгрөг)	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.								
Нийт дүн								

“Орон сууц, барилга, байгууламжийн төрөл” гэсэн хэсэгт Барилгын тухай хууль болон барилга байгууламжийн норматив баримт бичигт зааснаар орон сууц, барилга байгууламжийн төрлийг мэдүүлнэ.

“Улсын бүртгэлийн дугаар” тухайн хөрөнгийг бүртгэх эрх бүхий байгууллагаас бүртгэж, мэдээллийн санд тусгасан давхардахгүй дугаарыг бичнэ. Хэрэв улсын бүртгэлд бүртгээгүй бол холбогдох хэсгийн тайлбарт тодорхой бичнэ.

“Байршил /хаяг/” гэсэн хэсэгт Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэнээр, гадаад улс, оффшор, чөлөөт бүсэд байгаа бол түүнийг нотлох албан ёсны баримтыг, байршлыг тодорхой мэдүүлнэ.

“Хийц, талбайн хэмжээ, өрөөний тоо” гэсэн хэсэгт тухайн орон сууц, барилга, байгууламжийн талбайн хэмжээ, хийц, өрөөний тоог Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээнд эсхүл хүчин төгөлдөр бүхий бусад баримтад бичигдсэнээр мэдүүлнэ.

“Өмчлөгч/эзэмшигч/-ийн эцэг/эх/-ийн нэр, нэр” гэсэн хэсэгт Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэсэн, эсхүл гадаад улс, оффшор эсхүл чөлөөт бүсэд байгаа хөрөнгийг гэрчлэх албан ёсны баримтад заасан өмчлөгч/эзэмшигч/-ийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн/х/ нь нэрийг бичнэ.

“Анхны үнэ (төгрөг)” хэсэгт тухайн хөрөнгийг барьж байгуулах, бий болгоход зарцуулсан, эсхүл анх худалдан авахад мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдээс төлсөн үнийн дүнгээр илэрхийлэгдэх мөнгөн дүнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.

“Зах зээлийн үнэлгээ (төгрөг)” хэсэгт орон сууц, барилга, байгууламж нь Монгол Улсад байгаа бол жилийн эцсийн зах зээлийн үнээр, гадаад улс, оффшор болон чөлөөт бүсэд байгаа бол тухайн жилийн эцсийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлэн төгрөгөөр илэрхийлж мэдүүлнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” хэсэгт тухайн орон сууц, барилга, байгууламжийг өөрийн өмчлөлд шилжүүлэн авсан огноо, үнэ, санхүүгийн болон бусад эх үүсвэр /бэлэг, өв залгамжлал/-ийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

2.6.3. Тээврийн хэрэгсэл

Энэ хэсэгт **“Автотээврийн тухай хууль”**, **“Усан тээврийн тухай хууль”**, **“Иргэний нисэхийн тухай хууль”-д заасан** хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгсэл, “механикжсан тээврийн хэрэгсэл” буюу мопедоос бусад, хөдөлгүүрээр тоноглогдсон тээврийн хэрэгслийг мэдүүлнэ. Үүнд, бүх төрлийн ачааны болон суудлын автомашин, автобус, мотоцикл, үйлдвэрлэгчээс тусгайлан тоноглогдсон тээвэрлэлтийн зориулалт бүхий автомашин, бусад хүн болон ачаа тээвэрлэхэд зориулагдаагүй тусгай зориулалт бүхий автомашин, трактор, авто чиргүүл, үр тарианы комбайн, нисдэг тэрэг, нисэх онгоц, усан замаар зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн усан онгоц, чирэгч онгоц, чиргүүл онгоц, шумбагч онгоц, ахуйн болон спортын зориулалттай завь, усны мотоциклийг мэдүүлнэ.

3.3. Тээврийн хэрэгсэл							
№	Тээврийн хэрэгслийн зориулалт, марк, үйлдвэрлэсэн он	Өмчлөгч/ эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр	Улсын дугаар	Арлын дугаар	Анхны үнэ /төгрөг/	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.							
Нийт дүн							

“Тээврийн хэрэгслийн зориулалт, марк, үйлдвэрлэсэн он” гэсэн хэсэгт мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөл, эзэмшилд байгаа дээр дурдсан тээврийн хэрэгсэл тус бүрийн зориулалт, марк, тээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн оныг мэдүүлнэ.

“Өмчлөгч, эзэмшигчийн эцэг, эхийн нэр, өөрийн нэр” гэсэн хэсэгт мэдүүлэг гаргагч болон гэр бүлийн гишүүний нэр буюу тухайн тээврийн хэрэгслийг өмчлөгч/эзэмшигч/-ийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрийг бичнэ.

“Улсын дугаар”, “Арлын дугаар” гэсэн хэсэгт тухайн тээврийн хэрэгслийн улсын дугаар болон арлын дугаарыг мэдүүлнэ.

“Анхны үнэ (төгрөг)” хэсэгт тухай хөрөнгийг өөрийн болгоход зарцуулсан, эсхүл анх худалдан авахад мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдээс төлсөн үнийн дүнгээр илэрхийлэгдэх мөнгөн дүнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.

“Зах зээлийн үнэлгээ /төгрөг/” гэсэн хэсэгт мэдүүлж байгаа тээврийн хэрэгслийн үнэлгээг тухайн жилийн эцсийн үнэлгээгээр, төгрөгөөр илэрхийлж мэдүүлнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөлд байгаа тухайн тээврийн хэрэгслийн өмчилж, эзэмшиж эхэлсэн огноо, түүний санхүүгийн болон бусад эх үүсвэр /бэлэг, өв залгамжлал/-ийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

2.6.4. Тоног төхөөрөмж

Энэхүү зааврын 2.3-т зааснаас дээш үнийн дүнтэй хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ /үл хөдлөх хөрөнгө буюу орон сууц, барилга, байгууламж, газар, хөдлөх хөрөнгө буюу тээврийн хэрэгсэл, үнэт эдлэл, урлаг, түүх соёлын үнэт зүйлс, виртуал хөрөнгөөс бусад/. Тухайлбал мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдийн эзэмшил, өмчлөлд байдаг цахилгаан тоног төхөөрөмж, ахуйн болон жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, галт зэвсэг бусад хөдлөх хөрөнгө г.м.

3.4. Тоног төхөөрөмж					
№	Тоног төхөөрөмжийн зориулалт, марк, үйлдвэрлэсэн он	Өмчлөгч/эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Анхны үнэ /төгрөг/	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.					
Нийт дүн					

“Тоног төхөөрөмжийн нэр, зориулалт, марк, үйлдвэрлэсэн он” гэсэн хэсэгт мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөл, эзэмшил байгаа тоног төхөөрөмжийн нэр, тус бүрийн

зориулалт, марк болон гарал үүслийг тодорхойлсон баримт бичиг дэх тоног төхөөрөмжийн үйлдвэрлэсэн оныг мэдүүлнэ.

“Өмчлөгч, эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр” хэсэгт тухайн тоног төхөөрөмжийг өмчилж, эзэмшиж байгаа мэдүүлэг гаргагч болон гэр бүлийн гишүүний эцэг/эх/-ийн нэр, өөрийн/х/ нь нэрийг бичнэ.

“Анхны үнэ (төгрөг)” хэсэгт тухай хөрөнгийг өөрийн болгоход зарцуулсан, эсхүл анх худалдан авахад мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдээс төлсөн үнийн дүнгээр илэрхийлэгдэх мөнгөн дүнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.

“Зах зээлийн үнэлгээ” тухайн тоног төхөөрөмжийн жилийн эцсийн зах зээлийн үнэлгээг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл/эзэмшил/-д байгаа тухайн тоног төхөөрөмжийн эх үүсвэрийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

2.6.5. Мал, амьтан

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд зааснаар мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөл/эзэмшилд байгаа таван хошуу малаас гадна ашиг шимийг нь ашиглах болон бусад хэрэгцээнд зориулан үржүүлж байгаа амьтан /гахай, тахиа, зөгий, нохой бусад амьтан/-ны төрөл, тоо, зах зээлийн үнэлгээ, эх үүсвэр болон тухайн нутаг дэвсгэр байршил, малчны нэр, хаяг бусад мэдээллийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

3.5. Мал, амьтан						
№	Өмчлөгч, эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр	Төрөл	Тоо, толгой	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Байршил	Эх үүсвэрийн тайлбар
1.						
				Нийт дүн		

“Өмчлөгч, эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр” хэсэгт тухайн мал, амьтныг өмчилж, эзэмшиж байгаа мэдүүлэг гаргагч болон гэр бүлийн гишүүний эцэг/эх/-ийн нэр, өөрийн/х/ нь нэрийг бичнэ.

“Төрөл” гэсэн хэсэгт ямар төрлийн мал, амьтан болох талаар мэдүүлнэ.

“Тоо” гэсэн хэсэгт мэдүүлж байгаа мал, амьтны тоо толгойг мэдүүлнэ.

“Зах зээлийн үнэлгээ /төгрөг” гэсэн хэсэгт мэдүүлж байгаа мал, амьтны нэгжийн дундаж зах зээлийн үнийн дүнг төгрөгөөр илэрхийлж мэдүүлнэ.

“Байршил” тухайн мал, амьтны байрлаж байгаа нутаг дэвсгэр, малчны нэр, хаяг бусад мэдээллийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл/эзэмшил/-д байгаа тухайн мал, амьтны хөрөнгийн эх үүсвэрийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

2.6.6. Газар

Мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газрын мэдээллийг энэ хэсэгт тусгана.

3.6. Газар							
№	Өмчлөгч/эзэмшигч/ ашиглагчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Эрхийн төрөл, огноо /өмчлөх/эзэмших/ашиглах/	Улсын бүртгэлийн дугаар	Зориулалт, хэмжээ, хугацаа	Байршил (бүс нутаг), хаяг	Зах зээлийн үнэлгээ (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.							
					Нийт дүн		

“Өмчлөгч/эзэмшигч/ ашиглагчийн эцэг/эх/-ийн нэр, нэр” гэдэгт мэдүүлэг гаргагч болон гэр бүлийн гишүүний тухайн газрыг өмчлөгч/эзэмшигч/ашиглагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн/х/ нь нэрийг бичнэ.

“Эрхийн төрөл, огноо” гэдэгт мэдүүлэг гаргагч болон гэр бүлийн гишүүний өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа тухайн газрын талаар болон эрх шилжиж ирсэн огноог хамт мэдүүлнэ.

“Улсын бүртгэлийн дугаар” тухайн хөрөнгийг бүртгэх эрх бүхий байгууллага/гадаад, дотоод/-аас бүртгэж, мэдээллийн санд тусгасан давхардахгүй дугаар /нэгж талбарын дугаар/-ыг.

“Зориулалт, хэмжээ, хугацаа” гэсэн хэсэгт эрхийн гэрчилгээнд баталгаажсан зориулалт /гэр бүлийн хамтын хэрэгцээ хувийн гэр, орон сууцны хашаа барих, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал

ургамал тарих, давуу эрхээр эзэмшиж байгаа үр тарианы, төмс, хүнсний ногооны, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтын гэх мэт/-ыг, олгогдсон хэмжээ, хугацааг жилээр мэдүүлнэ.

“Байршил /бүс нутаг/, хаяг” гэсэн хэсэгт эрхийн гэрчилгээнд бичигдсэн байршил, хаягийг мэдүүлнэ. **“Зах зээлийн үнэлгээ /төгрөг/”** гэсэн хэсэгт газар өмчлөх/эзэмших/ашиглах эрхийн гэрчилгээтэй газрын үнийг тухайн жилийн эцсийн зах зээлийн ханшийн жишгээр, төгрөгөөр илэрхийлж бичнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн газар өмчлөх/эзэмших/ашиглах эрх бий болсон үндэслэл “төрөөс нэг удаа үнэгүй, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, давуу эрх г.м/-ийг дэлгэрэнгүй мэдүүлнэ.

2.6.7. Үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйл

Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд ашиглаж байгаа үнэт металл (алт, мөнгө, цагаан алт, паллади), үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйлийг урьд оны 12 сарын 31-ний байдлаар мэдүүлнэ.

3.7 Үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйл				
№	Хөрөнгийн нэр	Үнэлгээ (төгрөг)	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн тайлбар
1.				
	Нийт дүн			

“Хөрөнгийн нэр” хэсэгт үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйлийн төрөлд хамаарах хөрөнгийн нэрийг бичнэ.

“Үнэлгээ” хэсэгт тухайн үнэт эдлэл, урлаг, түүх соёлын үнэт зүйлсийн зах зээлийн үнэлгээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.

“Эзэмшигчийн нэр” хэсэгт Үнэт эдлэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйлийг эзэмшиж байгаа мэдүүлэг гаргагч, эсхүл түүний гэр бүлийн гишүүний нэрийг бичнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” хэсэгт тухайн хөрөнгийг хэзээ анх өөрийн болгож авсан, хэрэв худалдан авсан бол хэдэн төгрөгөөр хэнээс, хаанаас худалдан авсан зэргээ тайлбарлан бичнэ.

2.6.8. Бэлэн мөнгө, харилцах, хадгаламж, картын дансны үлдэгдэл

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд зааснаар мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний Монгол улс дахь болон гадаад улсын банк, санхүүгийн байгууллага, оффшор бүс дэх бүх төрлийн бэлэн мөнгө, мөнгөн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах, төлбөр төлөх зориулалттай төлбөрийн карт, цахим мөнгө зэрэг биет, биет бус хэрэгсэл дэх данс, картын үлдэгдэл, түүнчлэн хадгаламж, данс, бэлэн байгаа мөнгийг урьд оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төгрөгөөр илэрхийлж мэдүүлнэ. Гадаад валютыг мөн урьд оны 12 дугаар сарын 31-ний өдөр Монголбанкнаас зарласан валютын ханшаар төгрөгт хөрвүүлэн дүнг мэдүүлнэ. Хадгаламжийн хайрцагт хадгалуулсан мөнгө үүнд хамаарна. Энэ хэсэгт кредит /зээлийн/ картын мэдээллийг мэдүүлэхгүй.

3.8. Бэлэн мөнгө, харилцах, хадгаламж, картын дансны үлдэгдэл /өмнөх оны 12-р сарын 31-ний байдлаар/						
№	Бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж, карт, данс эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Хадгаламж/данс/карт эзэмшиж байгаа банк, санхүүгийн байгууллагын нэр, байршил	Дансны төрөл	Дансны дугаар	Мөнгөн дүн (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.						
					Нийт дүн	

“Бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж, карт, данс эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр” хэсэгт бүх төрлийн бэлэн мөнгө, төлбөрийн карт, цахим мөнгө, хадгаламж/харилцах данс/бэлэн мөнгө/банкны карт эзэмшигчийн буюу мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний эцэг /эх/-ийн нэр, нэрийг төрөл бус бүрээр нь жагсаан бичнэ.

“Хадгаламж/данс/карт эзэмшиж байгаа банк, санхүүгийн байгууллагын нэр, байршил” гэсэн хэсэгт мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний нэр дээр эзэмшиж байгаа Монгол Улс болон гадаад улс, оффшор бүс дэх банк, санхүүгийн байгууллага болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн албан ёсны нэршил, байршлыг тодорхой, жагсаан бичнэ.

“Дансны төрөл, дугаар” гэсэн хэсэгт тухайн банк, санхүүгийн байгууллага, оффшор бүсэд нээлгэсэн банкны болон харилцах дансны төрөл /хадгаламж (хугацаатай, хугацаагүй) цалингийн, энгийн харилцах гэх мэт/, дугаарыг бичнэ.

“Мөнгөн дүн /төгрөг/” гэсэн хэсэгт тухайн банк, санхүүгийн байгууллага, оффшор бүс дэх банк/харилцах данс/банкны картад хадгалагдаж байгаа мөнгөн хөрөнгө болон бэлэн мөнгөний нийт дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ. Ийнхүү мэдүүлэхэд доод, эсхүл дээд хязгаар хамаарахгүй.

“Эх үүсвэрийн тайлбар” гэсэн хэсэгт банк, санхүүгийн байгууллага, оффшор бүс дэх банк/харилцах данс/банкны картад байгаа мөнгө хөрөнгийн эх сурвалж буюу үүсвэрийг тодорхой бичнэ.

2.6.9. Виртуал хөрөнгө

Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн өмчлөл/эзэмшилд байгаа аливаа хэлбэрийн виртуал хөрөнгө буюу криптовалюта, койн, токен, Nonfungible tokens (NFT) зэргийг урьд оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар мэдүүлнэ.

3.9. Виртуал хөрөнгө (криптовалюта, койн, токен, NFT г.м.) /							
№	Эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр	Виртуал хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Анхны үнэ (төгрөг)		Зах зээлийн үнэлгээ (төгрөг) (өмнөх оны 12-р сарын 31-ний байдлаар)	Эх үүсвэрийн тайлбар
				Нэгжийн үнэ	Нийт үнэлгээ	Нэгжийн үнэ	
1.							
Нийт дүн							

“Эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр” хэсэгт виртуал хөрөнгө эзэмшигчийн буюу мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн /х/ нэрийг төрөл бус бүрээр нь жагсаан бичнэ.

“Виртуал хөрөнгийн нэр”, “Тоо ширхэг” хэсэгт тухайн виртуал хөрөнгийн нэрийг латин үсгээр Bitcoin, Ethereum, Tether, USD coin зэрэг хэлбэрээр, мөн тэдгээрийг тоо ширхэгийг бичнэ.

“Анхны үнэ (төгрөг)” хэсэгт тухай хөрөнгийг бий болгоход зарцуулсан, эсхүл анх худалдан авахад мэдүүлэг гаргагч болон түүний гэр бүлийн гишүүдээс төлсөн үнийн дүнгээр илэрхийлэгдэх мөнгөн дүнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.

“Зах зээлийн үнэлгээ” хэсэгт мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн эзэмшиж буй виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээг урьд оны 12 дугаар сарын 31-ний байдлаар мэдүүлнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” хэсэгт тухайн хөрөнгийг бий болгох, худалдан авахад зарцуулсан хөрөнгийн эх үүсвэрийг дэлгэрэнгүй байдлаар тайлбарлан бичнэ.

2.6.10. Авлага

Авлага хэсэгт мэдүүлэг гаргагч өөрөө болон гэр бүлийн гишүүний бусад хувь хүн, хуулийн этгээдээс буцаан авах нөхцөлтэй өгсөн /зээлдүүлсэн/ мөнгө, эд хөрөнгийг мэдүүлнэ.

3.10. Авлага						
№	Хувь хүн/хуулийн этгээдийн нэр	Авлага үүссэн огноо	Дүн /төгрөг/	Хүү/ алданги	Авлагын үлдэгдэл (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.						
Нийт дүн						

“Хувь хүн/хуулийн этгээдийн нэр” гэсэн хэсэгт мэдүүлэг гаргагчид эсхүл түүний гэр бүлийн гишүүнд авлага өгөх хувь хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийнх нь нэр, хуулийн этгээд бол албан ёсны нэрийг нэг бүрчлэн мэдүүлнэ.

“Авлага үүссэн огноо” гэсэн хэсэгт гэрээ, хэлцэлд заасан тухайн авлага үүссэн он, сар, өдрийг;

“Дүн /төгрөг/” хэсэгт анх авсан авлагын нийт мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлж мэдүүлнэ.

“Хүү/алданги” хэсэгт гэрээ, хэлцэлд заасан зээлийн хүү, хугацаа алдсан тохиолдолд тооцон авахаар тохирсон алдангийн хэмжээг бичнэ.

“Авлагын үлдэгдэл /төгрөг/” гэсэн хэсэгт авлагын үлдэгдлийг урьд оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон төгрөгөөр илэрхийлж мэдүүлнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” гэсэн тухайн авлага бий болсон үндэслэл, эх сурвалж буюу үүсвэрийг тодорхой бичнэ.

2.6.11. Зээл

Мэдүүлэг гаргагч өөрөө болон гэр бүлийн гишүүн нь аливаа банк, банк бус санхүүгийн байгууллага, хувь хүн, хуулийн этгээд /зээлдүүлэгч/-тэй байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу тогтоосон хугацаанд, эргэн төлөх нөхцөлтэйгөөр авсан мөнгө буюу зээлийг мэдүүлнэ. Тухайлбал, Арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, Засгийн газрын тусгай сан, санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагаа явуулдаг бүх төрлийн сан, төсөл, хөтөлбөр, түүнчлэн хувь хүн, хуулийн этгээдээс буцаан төлөх нөхцөлтэй авсан мөнгийг эд хөрөнгийг ойлгоно. Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эзэмшдэг кредит /зээлийн/ картын мэдээллийг мэдүүлнэ.

3.11. Зээл									
№	Зээл авсан хүний эцэг/эх/-ийн нэр, нэр	Зээлдүүлэгчийн нэр	Зээлийн хэмжээ (төгрөг)	Зээл авсан болон төлж дуусах огноо	Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн нийт дүн (төгрөг)	Зээлийн үлдэгдэл (төгрөг)	Зориулалт	Зээлийн барьцаа, батлан даагч	Тайлбар
1									
Нийт дүн									

“Зээл авсан хүний эцэг/эх/-ийн нэр, нэр” гэсэн хэсэгт мэдүүлэг гаргагч өөрөө эсхүл зээл авсан гэр бүлийн гишүүний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрийг бичнэ.

“Зээлдүүлэгчийн нэр” гэсэн хэсэгт мөнгө, эд хөрөнгийг зээлээр өгсөн хувь хүний эцэг/эх/, өөрийнх нь нэр, арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, Засгийн газрын тусгай сан, санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагаа явуулдаг бүх төрлийн сан, төсөл, хөтөлбөр, албан ёсны нэрийг бичнэ.

“Зээлийн хэмжээ /төгрөг/” гэсэн хэсэгт анх авсан зээлийн нийт хэмжээг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

“Зээл авсан болон төлж дуусах огноо” гэсэн хэсэгт зээл анх авсан болон төлж дуусах огноог бичнэ.

“Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн нийт дүн /төгрөг/” гэсэн хэсэгт урьд оны 1 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон зээл болон зээлийн хүүд төлсөн мөнгөний нийлбэр дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

“Зээлийн үлдэгдэл/төгрөг/” гэсэн хэсэгт тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон зээлийн үлдэгдлийг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

“Зээл авсан болон төлж дуусах огноо” гэсэн хэсэгт зээл авч эхэлсэн болон төлж дуусах огноог холбогдох гэрээ, хэлцэлд зааснаар бичнэ.

“Зориулалт” гэсэн хэсэгт зээлийг ямар үйл ажиллагаанд зориулан зарцуулахаар авсныг тодорхой бичнэ. /цалингийн, тэтгэврийн, орон сууцны, төслийн, эргэлтийн хөрөнгийн, малчны, хөрөнгө, оруулалтын гэх мэт/

“Зээлийн барьцаа, батлан даагч” гэсэн хэсэгт Зээлийн гэрээний үүрэг биелэхгүй байх нөхцөл ирээдүйд бий болох үед гэрээний үүргийг гүйцэтгүүлэх зорилготой хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эрхийг, мөн гуравдагч этгээд зээлдэгчийн нэрийн өмнөөс зээлийн гэрээний үүргийг эд хөрөнгөөр болон орлогоороо хариуцан төлөх үүрэг хүлээсэн этгээдийг зээлийн гэрээнд зааснаар бичнэ.

2.6.12. Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас

Энэ хэсэгт мэдүүлэг гаргагч өөрөө болон гэр бүлийн гишүүний Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд /ХК, ХХК, компанийн толгой, охин, хараат компани, компанийн нэгдэл, салбар, төлөөлөгчийн газар/, нөхөрлөл зэрэг ашгийн төлөө хуулийн этгээдэд эзэмшиж буй өмчлөлийн хувь, хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад нээлттэй, хаалттай үнэт цаасны талаар мэдүүлнэ. Тухайлбал, энэ хэсэгт компанийн хувьцаа (олон нийтэд нээлттэй арилжаалдаг болон арилжаалдаггүй), Засгийн газрын бонд, бусад бонд, вексель, хувьчлалын үнэт цаас/тасалбар, дериватив, опцион, фьючерс зэргийг мэдүүлнэ.

Мэдүүлгийн маягтын “Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд” хэсэгт мэдүүлсэн хуулийн этгээдэд хувь эзэмшдэг, эсхүл хөрөнгө оруулсан, эсхүл хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг эзэмшиж байгаа бол энэ хэсэгт хөрөнгийн хувь, хэмжээний талаар маягтын дагуу мэдүүлнэ.

3.12. Хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас						
№	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувь нийлүүлсэн/орлуулсан хөрөнгийн хэмжээ (төгрөг), хувь	Хөрөнгө оруулалтын төрөл, тоо	Нэгж хувьцааны анхны үнэ (төгрөг)	Тухайн жилд авсан ногдол ашиг (төгрөг)	Эх үүсвэрийн тайлбар
1.						
Нийт дүн						

“Хуулийн этгээдийн нэр, хэлбэр” гэсэн хэсэгт Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн албан ёсны нэр, хэлбэр /Хязгаарлагдмал хариуцлагатай компани ХХК, хувьцаат компани ХК, нөхөрлөл/-ийг бичнэ.

“Хувь нийлүүлсэн/оруулсан хөрөнгийн хэмжээ, хувь /төгрөг/” гэсэн хэсэгт мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн Монгол Улсын болон гадаад улсын ашгийн төлөө хуулийн этгээдэд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг мэдүүлнэ.

“Хөрөнгө оруулалтын төрөл, тоо” гэсэн хэсэгт мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо ширхэг, төрөл /энгийн, давуу эрхийн/-ийг бичнэ.

“Тухайн жилд авсан ногдол ашиг/төгрөг” гэсэн хэсэгт тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон компанийн Хувь нийлүүлэгч/хөрөнгө оруулагчид хуваарилсан ногдол ашгийг бичнэ.

“Эх үүсвэрийн тайлбар” гэсэн хэсэгт мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний худалдан авсан хувьцаа/үнэт цаасны тоо ширхгийг, худалдан авсан үнийг төгрөгөөр илэрхийлж, ийнхүү худалдан авсан эх үүсвэрийг тодорхой бичнэ.

2.6.13. Эрх, патент

Мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүний эзэмшиж байгаа биет бус хөрөнгө буюу оюуны өмчийн эрх, патент, барааны тэмдэг, ноу-хау, түүнтэй адилтгах бусад эрх, патентыг мэдүүлнэ. **“Зохиогчийн эрх эзэмшигч”** гэдгийг Зохиогчийн эрхийн тухай хуульд зааснаар буюу утга зохиол, урлагийн бүтээлтэй холбоотойгоор үүсэх зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг эдлэх хувь хүнийг, **“Патент, гэрчилгээ эзэмшигч”** гэдгийг патентын тухай хуульд зааснаар “шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент болон ашигтай загварын гэрчилгээ, түүнтэй холбоотой онцгой эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан зохиогч буюу түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийг тус тус ойлгоно.

3.13. Эрх, патент				
№	Төрөл	Эзэмшигчийн нэр	Олгосон байгууллага, огноо	Тайлбар
1.				

“Төрөл” хэсэгт эрх, патентын аль нь болохыг дурдан холбогдох мэдээллийг мэдүүлнэ.

“Эзэмшигчийн нэр” хэсэгт эрх/патент/гэрчилгээ эзэмшигчийн эцэг /эх/-ийн, өөрийн нэрийг эрх бүхий байгууллагаас олгосон бичиг баримтад тусгагдсан эзэмшигчийн нэрийг бичнэ.

“Олгосон байгууллага” хэсэгт мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүнд оюуны өмчийн эрх, патент, барааны тэмдэг, ноу-хау, түүнтэй адилтгах бусад эрх, патентыг хүлээн зөвшөөрч бүртгэн олгосон эрх бүхий байгууллагын нэрийг товчлохгүйгээр бичнэ.

“Тайлбар” хэсэгт эрх, патентыг хэзээ, хэрхэн олж авсан, түүнийг олж авахад ямар хэмжээний хөрөнгө зарцуулсан, хөрөнгийн эх үүсвэр нь юу болох талаар энэ хэсэгт бичнэ.

---oOo---

Авлигатай тэмцэх газар

**Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл,
тайлбарын маягт нөхөх заавар**

Огноо: 2024/.../...

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү зааврыг Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг болон УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 1.6-д заасныг үндэслэн боловсруулсан болно.

Нийтийн албан тушаалтан нь хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ үнэн зөв гаргахаас гадна ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг гаргах үүрэг хүлээдэг. Албан тушаалтнаас уг үүргийнхээ хэрэгжилтийг хангахад нь дэмжлэг болох зорилгоор ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягтын талбар дахь анхаарах асуудал, нэр томъёоны тодорхойлолт, түгээмэл гардаг асуултад хариулсан байдлаар уг маягт нөхөх зааврыг боловсруулав.

Санал, хүсэлт

Энэхүү маягт нөхөх зааврыг Авлигатай тэмцэх газраас тухай бүр боловсронгуй болгоход анхаарч ажиллаж байгаа бөгөөд заавартай холбоотой аливаа залруулга, санал, хүсэлтийг тус газрын contact@iaac.mn хаягаар ирүүлнэ үү.

Нэмэлт асуулт

Хэрэв Та ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар гаргах явцад энэхүү зааварт тодорхой тусгагдаагүй асуудалтай холбоотой нэмэлт асуулт гарвал өөрийн харьяа байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах Эрх Бүхий Албан Тушаалтан (ЭБАТ)-д хандана уу.

НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ

1.11. Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын зорилго

Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар нь нийтийн албан тушаалтны албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, цаашид үүсэж болох аливаа эрсдэлээс хамгаалах, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, нийтийн албанд шударга, ил тод байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг болох зорилготой.

1.12. Мэдэгдэл

“Мэдэгдэл” гэж нийтийн албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд тухайн үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ талаар маягтын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргасан мэдээллийг;

1.13. Тайлбар

“Тайлбар” гэж нийтийн албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд энэ талаар маягтын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргасан мэдээллийг;

1.14. Ашиг сонирхлын зөрчил

“Ашиг сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;

1.15. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал

“Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг;

1.16. Хамаарал бүхий этгээд

“Хамаарал бүхий этгээд” гэж нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;

1.17. Нэгдмэл сонирхолтой этгээд

“Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;

1.18. Хэн гаргах вэ?

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан доорх албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг гаргана. Үүнд:

- Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

- Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал.
- Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан.
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
- Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- Эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн;

1.19. Ямар тохиолдолд гаргах вэ?

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан нийтийн албан тушаалтан дараах тохиолдолд ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг гаргана. Үүнд:

- Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.
- Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд маягтын дагуу тайлбар гаргана.
- Үнэлгээний хорооны гишүүнээр томилогдохоос өмнө, эсхүл томилогдсон даруйд.
- Үнэлгээний хорооны гишүүн тендер шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл үүссэн, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал илэрсэн бол.

1.20. Хэнд гаргах вэ?

Тодорхой албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд мэдэгдэл, тайлбарыг маягтын дагуу шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж, гаргана.

1.21. Хэрхэн гаргах вэ?

Албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд тухайн албан үүрэг гүйцэтгэхээс татгалзаж мэдэгдэл, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд тайлбарыг маягтын дагуу шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж, шийдвэрлүүлэн өөрийн харьяа байгууллагын ЭБАТ-д хүлээлгэн өгч, Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем (<https://meduuleg.iaac.mn/>)-д бүртгүүлнэ.

1.22. Хариуцлагын тухай

Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Нийтийн албан тушаалтан нь ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар гаргах үүргээ биелүүлээгүй бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, дээрх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг бууруулах болон нийтийн албанаас халах хариуцлагыг хүлээлгэдэг.

ХОЁР. МАЯГТЫН ХЭСЭГ

2.1. Нийтийн албан тушаалтан

“Нийтийн албан тушаалтан” хэсэгт албан тушаалтан нь маягтын дагуу өөрийн мэдээлэл, ажиллаж буй байгууллага, мэдэгдэл тайлбарыг хүлээн авсан байгууллага, албан тушаалын нэр болон мэдэгдэл, тайлбар гаргаж буй үндэслэлийг үнэн зөв бичнэ.

Нэг. Нийтийн албан тушаалтан		
Эцэг/эхийн нэр:	Нэр:	Регистрийн дугаар:
Ажиллаж буй байгууллага:.....		Албан тушаал:.....
Мэдэгдэл, тайлбарыг хүлээн авсан байгууллагын нэр:		
Мэдэгдэл, тайлбар гаргаж буй үндэслэл:		

“Эцэг/эхийн нэр”, “Нэр”, “Регистрийн дугаар” хэсэгт албан тушаалтан өөрийн мэдээллийг бичнэ. Гадаад улсын иргэн бол “регистрийн дугаар” хэсэгт гадаад паспортын дугаар, эсхүл Монгол Улсаас олгосон бүртгэлийн дугаарыг бичнэ.

“Ажиллаж буй байгууллага” хэсэгт албан тушаалтан ажиллаж байгаа байгууллагын албан ёсны нэрийг тухайн байгууллагын шийдвэрээр баталгаажсанаар товчлохгүй бичнэ.

“Албан тушаал” хэсэгт албан тушаалтан эрхэлж байгаа албан тушаалын нэрийг тухайн байгууллагын шийдвэрээр баталгаажсанаар бичнэ.

“Мэдэгдэл, тайлбарыг хүлээн авсан байгууллагын нэр” хэсэгт албан тушаалтан тухайн байгууллагын албан ёсны нэрийг тухайн байгууллагын шийдвэрээр баталгаажсанаар /товчлохгүй/ бичнэ.

“Мэдэгдэл, тайлбар гаргаж буй үндэслэл” хэсэгт нийтийн албан тушаалтан ямар чиг үүрэг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй эсхүл албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал бий болсныг дэлгэрэнгүй бичнэ.

2.2. Мэдэгдэл, тайлбарын аль нь болохыг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ үү

Энэ хэсэгт албан тушаалтан мэдэгдэл болон тайлбар хэсгийн аль нь болохыг сонгож ✓ тэмдэглэгээ хийнэ.

Хоёр. Мэдэгдэл, тайлбарын аль нь болохыг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ үү.	
<input type="checkbox"/>	Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй (Зөвхөн гурав дахь хэсгийн мэдэгдлийг гаргах)
<input type="checkbox"/>	Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн (Зөвхөн дөрөв дэх хэсгийн тайлбарыг гаргах)

2.3. Мэдэгдэл

Энэ хэсэгт албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд гаргасан мэдэгдлийн талаарх тайлбарыг дэлгэрэнгүй бичнэ.

I урав. Мэдэгдэл

Нийтийн албан тушаалтан би дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд өөрийн хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх буюу албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэж, тухайн чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзаж байна.

Мэдэгдэл тодорхой бичих:

2.4. Тайлбар

Энэ хэсэгт албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд гаргасан тайлбарыг дэлгэрэнгүй бичнэ.

Дөрөв. Тайлбар

Нийтийн албан тушаалтан би дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” буюу өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүнтэй холбоотой зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу тайлбарлаж, тухайн чиг үүргийг гүйцэтгэхээс татгалзаж байна.

Тайлбар тодорхой бичих:

2.5. Нийтийн албан тушаалтны баталгаажуулалт:

Энэ хэсэгт ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, тайлбар гаргаж байгаа албан тушаалтан мэдэгдэл, тайлбар аль нь болохыг доогуур нь зурж, өөрийн нэр, албан тушаалын нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал, огноог бичнэ.

Тав. Нийтийн албан тушаалтны баталгаажуулалт:

_____ би нийтийн албан тушаалтны үүргээ чанд ухамсарлан энэхүү **мэдэгдэл/тайлбарыг** (аль нь болохыг доогуур нь зурах) үнэн зөв гаргасан болохоо үүгээр илэрхийлж баталгаажуулж байна.

..... (Албан тушаал) (Гарын үсэг) (.....) (Гарын үсгийн тайлал) (огноо)

2.6. Шийдвэрлэсэн байдал:

Энэ хэсэгт мэдэгдэл, тайлбарыг томилох эрх бүхий албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг даруй гаргаж, баталгаажуулах ба шийдвэрийг нийтийн албан тушаалтанд мэдэгдэж, маягыг ЭБАТ-д хүлээлгэн өгч, цахим системд бүртгүүлнэ.

Зургаа. Шийдвэрлэсэн байдал

Шийдвэр гаргах удирдах албан тушаалтан /нэр/ _____ би
нийтийн албан тушаалтан /нэр/ _____ -ийн/ын/ гаргасан мэдэгдэл,
тайлбарт үндэслэн тухайн чиг үүргийг гүйцэтгүүлэхийг зөвшөөрсөн эсэх:

 Тийм

 Үгүй

Хэрэв “Тийм” бол шалтгааныг сонгон ✓ тэмдэглэгээ хийнэ үү.

- тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн чиг үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй;
- дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;
- тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа.

Шийдвэр гаргасан удирдах албан тушаалтны баталгаажуулалт:

..... /...../
(Албан тушаал) (Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал) (огноо)

“Шийдвэр гаргах албан тушаалтан /нэр/” хэсэгт тухайн шийдвэр гаргаж буй эрх бүхий албан тушаалтан өөрийн нэрийг бичнэ.

“Нийтийн албан тушаалтан /нэр/” хэсэгт тухайн мэдэгдэл, тайлбарыг гаргасан нийтийн албан тушаалтны нэрийг бичнэ.

“Тухайн чиг үүргийг зөвшөөрсөн эсэх” хэсгээс “Тийм”, “Үгүй” шалтгааны аль нь болохыг сонгож ✓ тэмдэглэгээ хийнэ.

“Тийм” гэсэн шалтгааныг сонгосон бол маягтад байрлах гурван шалтгаанаас аль тохирохыг сонгож ✓ тэмдэглэгээ хийнэ.

“Шийдвэр гаргасан албан удирдах албан тушаалтны баталгаажуулалт” хэсэгт тухайн шийдвэр гаргаж буй эрх бүхий албан тушаалтан өөрийн нэр, гарын үсэг, гарын үсгийн тайлал, огноог бичнэ.

ЭБАТ-аас бөглөх хэсэг:**ЭБАТ-аас бөглөх хэсэг:**

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

(Гарын үсэг)

(Мэдэгдэл/тайлбарыг бүртгэсэн огноо)

---oOo---